Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл тухайн зорилгоор удирдагддаг ба гүйцэтгэл нь бодит үнэ цэнийн сууриар үзлэгдэг санхүүгийн хөрөнгө нь БҮЦАА-аар хэмжигдэнэ. Учир нь санхүүгийн хөрөнгийг гэрээт мөнгөн ургалыг цуглуулах эсвэл гэрээт мөнгөн ургалыг цуглувуж, борлуулах зорилгоор эзэмшээгүй болно

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(2) Санхүүгийн хоронгүүд ба санхүүгийн ор толборууд (үргэлжлэл)

Гэрээт мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн толбөрөөс бүрддэг эсэх үнэлгээ

Энэхүү үнэлгээний зорилгоор “үндсэн толбөр” гэдгийг санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэн гэж ойлгоно. “ХҮҮ” гэдэгт монголийн цаг хугацааны үнэ цэнийн төлбөр ба үндсэн төлбөрийн тодорхой цаг хугацааны зээлийн эрсдэлийн ба бусад эрсдэлийн төлбөр болон өртөг (жишээлбэл, хөрвөх чадварын эрсдэл болон захиргааны зардал) мөн ашгийн хэмжээг ойлгоно.

Гэрээний мөнгөн урсгал нь гагцхүү үндсэн болон хүүгийн толбөрөөс бүрддэг эсэхийг үнэлэхдээ Групп нь санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний заалтуудыг харгалзан үздэг. Үүнд, санхүүгийн хөрөнгийн гэрээ нь шалгуурыг хангах эсэхд нөлөөлөхүйцээр мөнгөн урсгалын орох хугацаа эсвэл дунг өөрчилж болох нөхцөл агуулсан эсэхийг үнэлж, дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- мөнгөн урсгалын хугацаа болон дунг өөрчлөх болзошгүй үйл явдлууд;
- хөшүүргийн шинж чанарууд;
- урьдчилан төлөх болон хугацаа сунгах нөхцөлүүд;
- тодорхой хөрөнгүүдээс Группийн мөнгөн урсгал хүлээн хүлээлтийг хязгаарлах заалтууд; ба
- мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөрийг өөрчлөх шинж чанарууд – жишээ нь: тогтмол хугацаанд хүүгийн түвшнийг дахин тохируулах.

Дахин ангилал

Групп санхүүгийн хөрөнгө удирдах бизнес загвартаяа өөрчлөлт оруулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөлтийн дараа дахин ангилахгүй.

Санхүүгийн ор толбор

Групп нь санхүүгийн болон зээлийн баталгаанаас бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр ангилдаг.

Үүсмэл хэрэглүүр

Групп нь гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх эрсдэлээ удирдах зорилгоор үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг ашигладаг. Үүсмэл хэрэглүүрүүдэд гадаад валютын форвард гэрээнүүд болон валютын своп гэрээнүүд багтана. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 27-д харуулав.

Үүсмэл хэрэглүүрүүдийг анх гэрээг байгуулсан өдрийн бодит үнэ цэниэр нь хүлээн зөвшөөрч, тайлангийн дараах үе бүрт бодит үнэ цэнээр дахин хэмжинэ. Үнэлгээний зөрүүнээс үүссэн олз, гарзыг тайлант үсийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь эерэг бол санхүүгийн хөрөнгөөр сөрөг бол санхүүгийн өр төлбөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

(iii) Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хоронго

Групп нь тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхээ санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдэлийн хамтаар бусдад шилжүүлсэн, эсвэл санхүүгийн хөрөнгийн бараг бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлэгүй боловч хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдээгүй бол санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхдөх хөрөнгийн дансны үнэ (эсвэл хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөгдөж буй хэсгийн дансны үнэ) болон (i) шинээр хүлээн авсан хөрөнгөөс шинээр тооцоолсон өр төлбөрийг хассаны дараах хүлээн авсан төлбөр болон (ii) бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзын нийлбэрийн зөрүүгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

БҮЦБДО-оор илэрхийлэгдэх өмчийн хөрөнгө оруулалтын үнэт цаасны бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн ашиг, алдагдал нь үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдхөгүй. Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөх нөхцөлийг хангасан боловч Групп үүсгэсэн, өөртөө хадгалсан хэсгийг тусдаа хөрөнгө эсвэл өр төлбөрөөр бүртгэнэ.

Групп нь санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгийг бусдад шилжүүлсэн боловч тэдгээр хөрөнгийн эсвэл тодорхой хэсгийнх нь бүх эсвэл бараг бүх эрсдэл, өгөөжийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдолд байдаг. Ийм тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Ийм ажил гүйлгээнд үнэт цаас зээлдүүлэх болон буцаан худалдан авах нөхцөлтэй ажил гүйлгээний борлуулалт ба буцаан худалдан авалт зэрэг багтана.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(г) Санхүүгийн хоригүүд ба санхүүгийн өр толборууд (үргэлжлэл)

(iii) Үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Групп нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн бүх эрдэл, өгөөжийг шилжүүлэгчий болон өөртөө ч хадгалаагүй боловч хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Групп нь уг хөрөнгийг өөрийн оролцооны хэмжээгээр буюу шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөд өртсон хэвээр байгаа хэмжээгээр бүртгэлдээ хэвээр үлдээнэ.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуур нь хөрөнгийг бүхэлд нь биш, харин тухайн хөрөнгийн хэсгийг эсвэл шаардлагатай үед ижил төстгэй санхүүгийн хөрөнгийг Группт бүхэлд нь шилжүүлэхэд мөн адил хамаарна. Хөрөнгийн тодорхой хэсгийг шилжүүлж байгаа бол тухайн хэсэг нь тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээ, хөрөнгийн тодорхой хэмжээний хувь эсвэл тусгайлан тодорхойлсон мөнгөн урсгалын хувь байх шаардлагатай.

Санхүүгийн өр толбор

Групп санхүүгийн өр толберийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрдог.

(iv) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр толберийн өөрчлөлт

Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд групп нь нөхцөл өөрчлөгдсөн хөрөнгийн мөнгөн урсгал эрс өөрчлөгдсөн эсэхийг үнэлдэг.

Хэрэв мөнгөн урсгал эрс өөрчлөгдсөн бол (“томуохон өөрчлөлт хийгдсэн” гэнэ) гэрээний эрхийн дагуу анхны санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалын хугацааг дууссан гэж үзнэ. Энэ тохиолдолд анхны санхүүгийн хөрөнгийг данснаас хасаж, шинэ санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэн дээр ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Өөрчлөлтийн хүрээнд хүлээн авсан аливаа шимтгэлийг дараах байдлаар бүртгэнэ:

- шинэ санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход гарсан төлбөр болон зардал нь хөрөнгийн анхны хэмжилтэд хамаарах ажил гүйлгээний буцаан олголт; ба
- үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарз хэмээн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн бусад төлбөрийг.

Зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс үүдэлтэй мөнгөн урсгалын өөрчлөлтийн зорилго нь эрс өөрчлөгдсөн нөхцөлтэй шинэ хөрөнгийг бий болгохоос илүүтэй хөрөнгийн анхны гэрээний нөхцөлийн дагуу төлбөрийг нөхөн боломжийг ихэсгэхэд оршино.

Групп мөнгөн урсгалыг хүлээн авахгүй өршөөх замаар санхүүгийн хөрөнгийг өөрчлөх төлөвлөгөөтэй бол уг өөрчлөлтийг хийхээс өмнө хөрөнгийг хэсэгчлэн данснаас хасах эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй (данснаас хасах бодлого доороос харна уу). Энэ аргачлал нь тоон үнэлгээний үр дүнд нөлөөлөх буюу үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй нөхцөлийг ихэнхдээ ий болгодог.

Хорогдуулсан өртөг эсвэл БҮЦБДО-оор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхд хүргэхгүй бол Групп нь хөрөнгийн анхны үр ашигт хүүгийн түвшнийг ашиглан санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолж өөрчлөлтийн олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд тохируулна.

Хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгүүдийн хувьд өөрчлөлтийн үед одоогийн зах зээлийн нөхцөлийг тусгахын тулд олз, гарзыг тодорхойлсон анхны үр ашигт хүүгийн түвшнийг залруулна. Өөрчлөлтөөс болж гарсан зардал, шимтгэл, мөн хүлээн авсан шимтгэлийн дүнгээр өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн дансны үнийг тохирууллаг ба өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийг үлдсэн хугацаанд хорогдуулдаг.

Хэрэв энэхүү өөрчлөлт нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс болж үүссэн бол олз, гарз нь үнэ цэнийн бууралтын гарзтай хамт толилуулагдана. Бусад тохиолдолд үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлогоор толилуулагдана.

Санхүүгийн өр толбор

Групп нь санхүүгийн өр төлбөрийг нөхцөл нь өөрчлөгдсөн болон өөрчлөгдсөн өр төлбөрийн мөнгөн урсгал хамаагүй өөр байгаа тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд өөрчлөгдсөн нөхцөлтэй шинэ санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хасагдсан санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ болон өөрчлөгдсөн нөхцөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн шинэ санхүүгийн өр төлбөрийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Төлсөн төлбөрт шилжүүлсэн санхүүгийн бус хөрөнгө (хэрэв байвал), шинэчилсэн санхүүгийн өр төлбөрийг багтаасан өр төлбөрийн үүрэг хүлээлт хамаарна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(2) Санхүүгийн хөрөнгүүд ба санхүүгийн өр төлбөрүүд (үргэлжлэл)

(iv) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлтийн (үргэлжлэл)

Хэрэв санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөлт гэж бүртгээгүй бол анхны үр ашигт хүүгийн түвшнийг ашиглан шинэчлэгдсэн мөнгөн ургалыг дискаунтчлан өр төлбөрийн хорогдуулсан өргтгийг тооцоолж, үүссэн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрно. Хөвөгч хүүтэй санхүүгийн өр төлбөрийн хувьд өөрчлөлтийн үед одоогийн зах зээлийн нөхцөлийг тусгахын тулд өөрчлөлтийн олз, гарзыг тодорхойлсон анхны үр ашигт хүүгийн түвшнийг залруулна. Аливаа зардал ба шимтгэл ийн өр төлбөрийн дансны үнийг залруулан хүлээн зөвшөөрөгддөг ба үүнийг өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн үлдсэн хугацаанд дахин тооцоолсон үр ашигт хүүгийн түвшнээр хорогдуулдаг. Өөрчлөлтөөс болж гарсан зардал, шимтгэлийн дүнгээр өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн дансны үнийг тохируулдаг ба үр ашигт хүүг дахин тооцоолж өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн үлдсэн хугацаанд хорогдуулдаг.

(v) Цэвэр дүнгээр илэрхийлэх нь

Групп нь хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь нэгтгэж, цэвэр дүнгээр нь илэрхийлэх нь хууль эрх зүйн үндэслэлтэй, цэвэр дүнгээр төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг барагдуулах зорилготой санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хооронд нэгтгэн санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

Орлого ба зардлыг зөвхөн СТОУС-ын Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу зөвшөөрөгдсөн тохиолдолд, эсвэл Группийн арилжааны үйл ажиллагаа гэх мэт ижил төстэй ажил гүйлгээний үр дүнд үүссэн олз, гарзыг цэвэр хэлбэрээр толилуулдаг.

(vi) Үнэ цэнийн бууралт

Групп нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэнээс бусад дараах санхүүгийн хэрэгслийд дээр тооцдог:

- өрийн хэрэгслийд болох санхүүгийн хөрөнгүүд;
- санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт;
- гаргасан санхүүгийн баталгааны гэрээ; ба
- олгосон зээлийн баталгаа.

Өмчийн хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт байгуулдаггүй.

Групп үнэ цэнийн бууралтын алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжих ба дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн ашиглалтын хугацааны турших хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмждэг. Үүнд :

- Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөө үүсээгүй бусад санхүүгийн хэрэгслийд (санхүүгийн түрээсэнд оруулсан цэвэр хөрөнгө хөрөнгө оруулалтаас бусад).

Групп нь зээлийн эрсдэлийн зэрэглэл нь нийтээр хүлээн зөвшөөрөгдох “Хөрөнгө оруулалтын зэрэглэл” гэсэн тодорхойлолттой нийцэж байвал өрийн хөрөнгө оруулалтын баталгааг зээлийн эрсдэл багатай гэж үздэг. Групп нь бусад санхүүгийн хэрэглүүрд зээлийн эрсдэл байх нөхцөлийг хэрэглэхгүй.

12 сард ногдох хүлээгдэж буй алдагдал гэдэг нь тайлант өдрөөс хойших 12 сарын дотор санхүүгийн хэрэглүүрийн төлбөрийн чадваргүй болохоос хүлээгдэж буй алдагдлын хувийг илэрхийлнэ. 12 сард ногдох хүлээгдэж буй алдагдалыг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүрийг “Түвшин 1” санхүүгийн хэрэглүүр гэж нэрлэдэг.

Санхүүгийн хөрөнгийн төлөгдөж дуусах хугацаа хүргэлх нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн алдагдалтай санхүүгийн хэрэглүүр “Түвшин 2” (хэрэв анх хүлээн зөвшөөрөлсөн үеэс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн, гэхдээ санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад ороогүй) ба санхүүгийн хэрэглүүр “Түвшин 3” (хэрэв санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэн буурсан үед) гэж нэрлэнэ.

Хүлээгдээж буй эрсдэлийн алдагдлын хэмжсилт

Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь зээлийн алдагдлын магадлалаар жинлэсэн тооцоолол юм. Энэ нь дараах байдлаар хэмжигдэнэ:

- тайлганалын өдрөөр үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хөрөнгүүд: бүх мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэн (жишээ нь: гэрээний дагуух байгууллагын мөнгөн ургал болон Группийн авахаар хүлээгдэж буй мөнгөн ургалын зөрүү)

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(г) Санхүүгийн хоронгүүд ба санхүүгийн ор толборуүд (үргэлжлэл)

(vi) Үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

- тайлагналын өдрөөр үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд: дансны нийт үнэ болон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүү
- олгогдоогүй зээлийн үргүүд: хэрэв үүргээ цуцалсан бол Группит өгөх гэрээний мөнгөн урсгал болон Групп хүлээн авах мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зорүү.

Бүтцийн өөрчлөлтөд орсон санхүүгийн хоронго

Хэрэв санхүүгийн хөрөнгийн нөхцөлүүд дахин хэлэлцэгдсэн эсвэл өөрчлөгдсөн эсвэл зээлдэгчийн санхүүгийн хүндэрэлээс үүдэн шинэчлэгдсэн бол санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэн хүлээгдэж буй эсслийн алдагдлыг дараах байдлаар тооцоолио.

- Хэрэв хүлээгдэж буй бүтцийн өөрчлөлт нь одоогийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөлтөд хүргэхгүй бол өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь одоогийн хөрөнгийн мөнгөний дутагдлын тооцоололд орсон байна.
- Хэрэв хүлээгдэж буй бүтцийн өөрчлөлт нь одоогийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэх бол шинэ хөрөнгийн хүлээгдэж буй бодит үнэ цэн одоогийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийн үеийн хамгийн сүүлийн мөнгөн урсалаар хэмжигдэнэ. Энэ дун нь одоогийн хөрөнгийн анхны үр ашигт хүүгийн түвшнээр үл хүлээн зөвшөөрөлтийн хүлээгдэж буй өдрөөр дискаунтлагдсан одоогийн санхүүгийн хөрөнгийн мөнгөний дутагдлын тооцоололд орсон дун юм.

Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хоронгүүд

Групп хорогдуулсан өргөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон БҮЦБДО-оор илэрхийлэгдсэн өрийн санхүүгийн хэрэглүүрүүд, мөн санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэн нь буурсан эсэхийг тайлант үе бүрд үнэлдэг. Санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалын тооцоололд сөргөөр нөлөөлөх нэг буюу түүнээс олон үйл явдал гарсан тохиолдолд үнэ цэн нь буурсан гэж үзнэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэн буурсан нотолгоонд дараах ажиглагдахуйц тоо баримтууд хамаарна:

- Зээлдэгчийн санхүүгийн мэдэгдэхүйц хүндэрлэлтэй байдал;
- Гэрээний хугацаа хэтрэлтгэй эсвэл дефолт болсон зэрэг гэрээний зорчил;
- Группийн авч хэлэлцэхээргүй нөхцөлөөр зээл ба урьдчилгаанд Групп бүтцийн өөрчлөлт оруулах;
- Зээлдэгч нь дампуурах эсвэл түүнд санхүүгийн бүтцийн өөрчлөлт орох магадлалтай байх; эсвэл
- Санхүүгийн хүндэрэлээс болж үнэт цаасыг арилжих идэвхтэй зах зээл байхгүй болох.

Зээлдэгчийн нөхцөл байдал муудсаны улмаас бүтцийн өөрчлөлтөд орсон зээлийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авахгүй байх эрдэл мэдэгдэхүйц буурсан, үнэ цэнийн бууралтын бусад үзүүлэлт байхгүй тохиолдолд зээлийн үнэ цэнэ буурсан гэж үздэг.

Хүлээгдээс буй зээлийн алдагдлын санг санхүүгийн байдлын тайланд толилуулах

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар толилуулна:

- хорогдуулсан өргөөрх санхүүгийн хөрөнгүүд: хөрөнгийн дансны үнээс хасна ;
- зээлийн баталгаа: ерөнхийдөө нөөц үүсгэнэ;
- Санхүүгийн хэрэглүүрүүд нь олгогдсон болон олгогдоогүй зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан бөгөөд Групп нь зээлийн баталгааны бүрэлдэхүүн хэсэг дэх ХБЗА-ийг олгогдсон бүрэлдэхүүн хэсгийнхээс тусад нь тодорхойлох боломжгүй тохиолдолд Групп зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн ХБЗА-ыг хамтад нь толилуулдаг. Нийт дун нь олгогдсон зээлийн хэсгийн нийт дунгээс хасагдаж тайлагнагдана. Зээлийн бүрэлдэхүүн хэсгийн нийт үнийн дунгээс хэтэрсэн нөөцийг бодит үнэ цэнийн нөөц байдлаар үзүүлнэ;
- БҮЦБДО-р илэрхийлэгдэх өрийн хэрэглүүрүүд: эдгээр хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнийр илэрхийлэгдсэн учраас санхүүгийн байдлын тайланд эрсдэлийн алдагдлын нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй. Гэхдээ алдагдлын нөөцийг бодит үнэ цэнийн нөөцөд бүртгэнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(2) Санхүүгийн хоронгүүд ба санхүүгийн ор толборууд (үргэлжлэл)

(vi) Үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Данснаас хасах

Зээл болон өрийн үнэт цаасыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөн авах үндэслэл бүхий хүлээлт байхгүй болсон үед данснаас хасдаг (бүхэлд нь эсвэл хэсэгчлэн). Энэ нь Групп зээлдэгчийг данснаас хасагдах хөрөнгийг төлөх хангалттай мөнгөн хөрөнгө эсвэл орлогын эх үүсвэр байхгүй гэж тодорхойлсон үед ихэвчлэн тохиолддог. Энэхүү үнэлгээг тусгайлсан хөрөнгийн түвшинд гүйцэтгэдэг.

Данснаас хассан хөрөнгүүдийн хувьд Группийн өр төлбөрөө нөхөн авах журмын дагуу төлүүлэх үйл ажиллагаа авч болно.

(d) Монго ба түүнтэй адилтгах хоронго

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд банканд байршиулсан хязгаарлагдаагүй харилцах болон бодит үнэ цэнийн өөрчлөлтөд орох эрсдэл бага, анх авсан өдрөөс 3 сар болон түүнээс доош хугацаатай банканд байршиулсан мөнгөн хөрөнгө багтах ба богино хугацааны үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг харилцах, хадгаламжаас бурдаж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь санхүүгийн байдлын тайландаа хорогдуулсан өртгөөр илэрхийлэгддэг.

(e) Хөрөнгө оруулалтын үнэт цаас

Хөрөнгө оруулалтын үнэт цаасанд дараах зүйлс орно:

- хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өрийн хөрөнгө оруулалтын үнэт цаас; эдгээрийг анх бодит үнэ цэн дээр шууд холбогдон гарсан гүйлгээний зардлыг нэмэн, дараа нь үр ашигтай хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжин;
- БҮЦБДО-оор илэрхийлэгдсэн өрийн үнэт цаас.
- Өмчийн хөрөнгө оруулалт

БҮЦБДО-оор илэрхийлэгдсэн өрийн үнэт цаасны хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн нэгэн адил ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдхөн дараах зүйлээс бусад тохиолдолд олз, гарзыг БДО-д хүлээн зөвшөөрно.

- үр ашигт хүүгийн аргыг ашигласан хүүгийн орлого;
- ХБЗА ба буцаалт; болон
- Гадаад валютын арилжааны олз, гарз.

БҮЦБДО-оор хэмжигдсэн өрийн үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөх үед өмнө нь БДО-д хүлээн зөвшөөрсөн байсан хуримтлагдсан олз, гарзыг өмчөөс ашиг, алдагдал руу дахин ангилна.

Групп нь арилжааны зорилгоор эзэмшидэггүй өмчийн хэрэглүүрүүд дэх зарим хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг БДО-ын өөрчлөлтөөр толилуулахаар сонгож болно. Энэхүү сонголтыг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хөрөнгө оруулалт тус бүр дээр эргэлт буцалтгүйгээр хийж болно.

Ийм өмчийн хэрэглүүрүүдийн олз, гарзыг ашиг, алдагдлаар дахин ангилдаггүй ба үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөхгүй. Ногдол ашиг нь хөрөнгө оруулалтын өргийн нөхөлтийг илэрхийлтэй бол ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ тохиолдолд БДО-д хүлээн зөвшөөрнө. БДО-д хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан олз, гарзыг хөрөнгө оруулалтыг борлуулах үед хуримтлагдсан ашиг руу шилжүүлийн.

(f) Үндсэн хоронго

Хэмжилт ба хүлээн зөвшөөрөлт

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр нь бүртгэдэг. Үндсэн хоронгийн өртгөт тухайн хөрөнгийг худалдан авах болон барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршиулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан бусад зардууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлцуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардуудыг хамааруулна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(e) Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой хэсгийн элэгдүүлэх хугацаа тухайн үндсэн хөрөнгөөс ялгаатай бол тэдгээрийг үндсэн хөрөнгийн тусдаа зүйл (гол бүрэлдэхүүн) гэж үзнэ.

Дараа үеийн зардал

Групп нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр иэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг буурууна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглагдах жилийнх нь туршид шулуун шугамын аргаар тооцон байгуулдаг. Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дунд багтсан гол бүрэлдэхүүн хэсгийн ашиглагдах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрт тусад нь элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассаны цэвэр орлогын зөрүүгээр үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз, гарзыг тухайн жилийн бусад үйл ажиллагааны бус орлого (зардал)-оор хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцуулэх хугацаанд тооцсон эдийн засгийн ашиглагдах хугацаа дараах байдалтай байна.

Ашиглалтын хугацаа

Барилга	25 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2 жил

Элэгдэл тооцох арга, ашиглалтын жил болон үлдэх өртгийг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг ба шаардлагатай бол залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

(ж) Биет бус хөрөнгө

Худалдан авсан программ хангамжийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэдэг. Программ хангамжийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг иэмэгдүүлэх тохиолдолд холбогдон гарсан аливаа дараа үеийн зардлыг капиталжуулна. Бусад гарсан зардлуудыг гарсан тухай бүрд нь ашиг, алдагдлаар бүртгэдэг.

Программ хангамжийн хорогдуулгыг тэдгээрийг ашиглах боломжтой болсон өдрөөс нь эхлэн тооцсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцдог. Тайлант жилийн программ хангамжийн тооцоолсон ашиглагдах хугацаа нь 10 жил байна. Тодорхой хугацаанд ашиглагдах биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон хорогдуулах аргыг тайлант үе бүрийн эцэст хянаж үздэг.

(з) Гаргасан өрийн хэрэглүүр ба зээлээр авсан санхүүжилт

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээлэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцоходоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Групп нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийг бүртгэлд тусгахдаа, эхлээд тухайн хэрэглүүр нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэглүүр болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НБОУС 32-и дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Групп нь санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Группд санхүүгийн өр төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэглүүрийг эзэмшигчид, Группийн өөрийн хөрөнгөнд хөрвөх боломж олгож байвал. Хөрвөх хэрэглүүрийн өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдхөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэглүүрийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хуваарилахдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэглүүрийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(3) Гаргасан өрийн хэрэглүүр ба зээлээр авсан санхүүжилт (үргэлжлэл)

Нийлмэл санхүүгийн хэрэглүүрд агуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хорвх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэглүүрийн үнэ цэн нь (худалдан авах опцион гэх мэт) өр төлбөрийн бүрэлдэхүүнд багтана.

(a) Итгэлцэл

Итгэлцэл нь харилцагчдаас хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу байршуулсан хадгаламжийг багтаана (Тодруулга 25). Ахны тооцооллоос хойш, харилцагчдаас татсан итгэлцлийг үр ашигт хүүгийн түвшнийг ашиглан хорогдуулсан өргөөр тооцоолно.

(b) Хувьцаат капитал

(i) Энгийн хувьцаа болон давуу эрхийн хувьцаа

Энгийн хувьцаа болон давуу эрхийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилагддаг. Энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа болон хувьцааны опционыг гаргахтай шууд холбогдон гарах нэмэлт зардлыг аливаа татварын нөлөөлөлтгүй цэвэр дүнгээр өмчийн хэсгийг бууруулах байдлаар хүлээн зөвшөөрнө. Худалдан авах, эргүүлэн худалдан авах, худалдан авах опцион зэргийг агуулаагүй энгийн хувьцаа болон давуу эрхийн хувьцааг өмчийн хэсэгт ангилдаг. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбогдон гарсан нэмэлт зардлыг хувьцааны орлогоос татварын суутгалаар бууруулж, өмчийн хэсэгт тусгана. Хувьцааны орлогоос орлогын нэрлэсэн үнээс давсан хэсгийг нэмж төлөгдсөн капитал гэж үзэж, өмчийн хэсэгт оруулна.

(ii) Нэмж төлөгдсөн капитал

Нэрлэсэн үнээс хэтэрсэн дүнг нэмж төлөгдсөн капитал гэж үзнэ. Нэмж төлөгдсөн капитал нь мөн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн нэмэгдлээс үүсдэг.

(iii) Зохицуулалтын нөөц

Зохицуулалтын нөөц нь үндсэндээ СЗХ-ны журмын дагуу өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан болон СТОУС-ын дагуу тогтоосон үнэ цэнийн бууралтын сан болон СЗХ-ны шаардлагын дагуу байгуулсан бусад нөөцийн хоорондын зөрүүг илэрхийлдэг.

(iv) Бодит үнэ цэнийн нөөц

Бодит үнэ цэнийн нөөц нь БҮЦБДО-оор илэрхийлэгдсэн өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлтөөс ХБЗА-ын нөөцийг хасаж, БҮЦБДО-д байгаа өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлтөөс бүрдэнэ.

(k) Ажилчдын тэтгэмж

(i) Богино хугацаат ажилтны тэтгэмж

Ажилчдын богино хугацаат тэтгэмж гэдэгт ажилтан Группт үзүүлсэн үйлчилгээнийхээ хариуд тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмжийг хэлнэ. Ажилтан нь тайлант үеийн турш Группт үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн үйлчилгээний хариуд төлөгдөхөөр хүлээгдсэн ажилтны богино хугацааны тэтгэмжийн дискаунтилагаагүй дүнг хүлээн зөвшөөрдөг.

(ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Хуульд заасны дагуу аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухай бүрд нь дэлгэрэнгүй орлогын тайландаа зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

(l) Хүү

Үр ашигт хүүгийн түвшин

Хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолон ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. "Үр ашигт хүү" гэдэг нь ирээдүйд төлөгдхөө эсвэл хүлээн авах мөнгөн ургалыг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаанд хорогдуулж:

- санхүүгийн хөрөнгийн дансны үнэ; эсвэл
- санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (ургэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (ургэлжлэл)

(л) Хүү (ургэлжлэл)

Худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай зээлийн хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэгслүүдийн үр ашигт хүүгийн түвшнийг тооцоолохдоо Групп нь санхүүгийн хэрэглүүрүүдийн гэрээний иөхцөлийн дагуу ирээдүйн бүх мөнгөн ургалыг тооцох боловч хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцохгүй. Худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай зээлийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулсан үр ашигт хүүгийн түвшнийг тооцон хүлээгдэж буй алдагдлын ирээдүйн мөнгөн ургалыг тооцно.

Үр ашигт хүүгийн түвшнийг тооцоолоход гүйлгээний зардал, хураамж, төлбор хийсэн эсвэл хүлээн авсан хугацаа зэргийг авч үздэг бөгөөд эдгээр нь үр ашигт хүүгийн салшгүй хэсэг байна. Гүйлгээний зардалд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах болон борлуулахтай шууд хамааралтай нэмэгдэл зардлууд багтана.

Хорогдуулсан ортог болон дансны нийт үнэ

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн “хорогдуулсан ортог” нь тэдгээрийн анхны хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлөлтийг хасаж, анхны болон эцсийн дунгийн зорүүгээр үр ашигт хүүгийн түвшнийг ашиглан хуримтлагдсан хорогдуулалтыг тооцож нэмэх эсвэл хасна. Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг тохируулсан дунг хэлнэ.

Хорогдуулсан ортгөөр тооцоолсон “санхүүгийн хөрөнгийн дансны нийт дүн” нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг тохируулахаас өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг хэлнэ.

Хүүгийн орлого, зардлын тооцоолол

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүгийн түвшнийг тэдгээрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед тооцоолно. Хүүгийн орлого ба зардлыг тооцоолохдоо, хөрөнгийн дансны нийт дүнд (хөрөнгө нь үнэ цэнийн бууралтгүй байх үед) эсвэл өр төлбөрийн хорогдуулсан өртөгт үндэслэн үр ашигт хүүгийн хувиар тооцоолно. Зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийг тусгахын тулд хөвөгч хүүтэй хэрэгслүүдийн мөнгөн ургалыг дахин үзэлэх замаар үр ашигт хүүгийн түвшний шинэчилдэг.

Гэсэн хэдий ч, анхны хүлээн зөвшөөрөлтийн дараагаар үнэ цэнийн бууралттай болсон санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үндэслэн үр ашигт хүүгийн хувиар хүүгийн орлогыг тооцоолно. Хэрэв тухайн хөрөнгө нь цаашид үнэ цэнийн бууралтгүй болбол хүүгийн орлогын тооцоолол нь буцаад дансны нийт дүнгийн тооцоолол руу шилжихгүй.

Толилуулга

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан үр ашигт хүүгийн орлогод дараах зүйлсийг бүртгэнэ:

- хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү;
- БҮЦБДО-р хэмжигдсэн өрийн хэрэгслүүдийн хүү;

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан хүүгийн зардалд дараах зүйлсийг бүртгэнэ:

- хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр;
- түрэсийн өр төлбөрийн хүүгийн зардал.

Арилжаалах хөрөнгө ба өр төлбөрийн хүүгийн орлого, зардлыг нь Группийн арилжааны үйл ажиллагаанд хамааралтай гэж үзэн, арилжааны хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдтэй хамт цэвэр орлогоор толилуулдаг.

БҮЦАА-аар илэрхийлэгдсэн бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хүүгийн орлого, зардал нь БҮЦАА-аар хэмжигдсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлогоор толилуулагдана.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(м) Хураамж ба шимтгэл

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрт нөлөөлөх үр ашигт хүүгийн хэмжилтэд хураамж ба шимтгэлийн орлого, зардал багтдаг.

Бусад хураамж ба шимтгэлийн орлогод дансны үйлчилгээний хураамж, хөрөнгө оруулалтын удирдлагын хураамж, борлуулалтын хураамж, байршуулалт болон хөрвүүлэлтийн хураамж эзэрг орох бөгөөд холбогдох үйлчилгээг үзүүлэх үед нь хүлээн зөвшөөрдөг. Хэрэв зээлийг дуусгавар болох хугацаанаас нь өмнө хаахаар төловлөөгүй бол холбогдох зээлийн хураамжийг шулуун шугамын аргаар тухайн зээлийн дуусах хүртэл хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

Группийн санхүүгийн тайланд санхүүгийн хэрэгслийдээр хүлээн зөвшөөрөгдсөн харицагчтай байгуулсан гэрээний зарим хэсэг нь СТОУС 9-ийн хамрах хүрээнд, зарим хэсэг нь СТОУС 15-ын хүрээнд хамаарч болно. Ийм тохиолдолд, Групп эхлээд СТОУС 9-ийн хамрах хүрээнд хамаарах хэсгийг СТОУС 9-ийн дагуу салган хэмжинж, үйлсэн хэсгийг СТОУС 15-ын дагуу хэмжинэ. Бусад хураамж, шимтгэл нь гүйлгээ болон үйлчилгээний хураамжтай голдуу хамаарлтай ба тухайн үйлчилгээг авсан үед нь зардлаар бүртгэнэ.

(и) Ногдол ашгийн орлого

Ногдол ашгийн орлогыг ногдол ашиг авах эрх үүссэн үед ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(о) Бодит үнэ цэнийг ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх бусад санхүүгийн хэрэглүүрүүдийн цэвэр орлого

БҮЦАА-аар хэмжсэн бусад санхүүгийн хэрэглүүрийн цэвэр орлого нь эрсдэлийг удирдах зорилгоор эзэмшиж буй арилжаалаагүй арилжааны бус үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд, БҮЦАА-аар хэмжсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон зайлшгүй БҮЦАА-аар хэмжигдэх арилжааны бус хөрөнгүүдтэй холбоотой. Энэ нь бодит үнэ цэнийн өөрчлөлт, хүү, ногдол ашиг болон гадаад валютын зөрүүг багтаасан байна.

(о) Түрээс

Гэрээг анх байгуулах үед Групп нь тухайн гэрээ нь түрээсийн гэрээ юу эсвэл түрээс агуулсан гэрээ юу гэдгийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь тодорхой төлбөр хүлээн авснаар тухайлсан хөрөнгийн хэрэглээг тодорхой хугацаанд хянах эрхийг олгож байвал тухайн гэрээг түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулсан гэрээ гэж үзнэ. Тухайн хөрөнгийг ашиглах эрхийн хяналт шилжсэн эсэхийг үнэлэхдээ Групп нь СТОУС 16-д заасан түрээсийн тодорхойлолтыг ашигласан.

(i) Групп түрээслэгч байх

Түрээсийн бүрэлдэхүүнийг агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Групп гэрээнд тусгасан үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрд хуваарилдаг. Салбар болон оффисын барилгын түрээнчүүдийн хувьд Групп нь түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгах аргыг сонгоогүй ба түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг бүрэлдэхүүн хэсэг гэж бүртгэнэ.

Групп нь түрээс эхлэх өдөр ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хэмжих бөгөөд үүнийг түрээсийн эхний өдөр болон түүнээс өмнө хийсэн түрээсийн төлбөрөөр тохируулсан түрээсийн өр төлбөрийн анхны дүн, аливаа анхдагч шууд зардлууд болон хөрөнгийг буулагах, сэргээн засварлахад түрээслэгчээс гарах аливаа тооцоолсон өртөг, мөн түрээсийн урамшууллыг хассан дүнгээр илэрхийлдэг.

Түрээсийн хугацаа дуусгавар болох үед ашиглах эрхтэй хөрөнгийг худалдан авах сонголтыг гэрээнд заасан эсвэл түрээсийн хугацааны эцэст тухайн түрээсийн хөрөнгийн өмчлөх эрх Группт бүрэн шилжихээс бусад үед ашиглах эрхтэй хөрөнгийг гэрээ эхэлсэн өдрөөс дусасаа өдөр хүртэл шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Энэ тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийг тухайн хөрөнгийн ашиглалтын жилээр элэгдүүлэх бөгөөд ашиглалтын жилийг үндэсн хөрөнгийн ашиглалтын жилийг тодорхойлох суурьтай ижил зарчмаар тодорхойлдог. Түүнчлэн, ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнийг аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлаар бууруулж, түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтээр тохируулдаг.

Түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ түрээсийн эхний өдрөөрх төлөгдөөгүй түрээсийн төлбөрүүдийг түрээст агуулагдсан нуугдмал хүүгийн хувь хэмжээг эсвэл уг хувь хэмжээг тодорхойлох боломжгүй бол Группийн осон нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг ашиглан дискаунтлан өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Групп осон нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг дискаунтын түвшин гэж авч үздэг. Групп нь осон нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг хэд хэдэн хөндлөнгийн эх үүсвэрээс хүүгийн хувь хэмжээг авах замаар тодорхойлдог бөгөөд түрээсийн нөхцөл, түрээслэсэн хөрөнгийн төрлийг илэрхийлэх тодорхой тохируулгуудыг хийдэг.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(a) Түрээс (үргэлжлэл)

Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд багтсан түрээсийн төлбөрт дараах зүйлүүд багтдаг:

- тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр хамаарна);
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, эхний өдөр индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн анхны хэмжилтээр;
- үлдэх өртийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүн;
- Группийн худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол уг сонголтыг хэрэгжүүлэх үнэ. Үүнд, Групп түрээсийг сунгана гэж үзвэл сунгалтын нэмэлт төлбөр, түрээсийн хугацааг эрт цуцлах торгууль зэрэг хамаарна.

Түрээсийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хэрэв индекс эсвэл хувь хэмжээнээс шалтгаалан Группийн ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдхө, үлдэх өртийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд өөрчлөйт орох, худалдан авалт хийх, сунгах эсвэл цуцлах эсэхэд өөрчлөйт орох эсвэл үндсэн түрээсийн төлбөрийг шинэчлэх тохиолдолд түрээсийн өр төлбөрийг дахин хэмждэг. Түрээсийн өр төлбөрийг ийм байдлаар дахин хэмжихэд ашиглах эрхтэй хөрөнгийн дансанд холбогдох тохицуулгыг хийдэг. Хэрэв ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ тэг болж буурсан байсан бол тохицуулгыг ашиг, алдагдалд бүртгэдэг.

Групп нь санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхтэй хөрөнгийг “үндсэн хөрөнгө”, түрээсийн өр төлбөрийг “бусад өр төлбөр” хэсэгт тусгадаг.

Богино хугацааны түрээс ба бага ортог бүхий түрээс

Групп бага үнэтэй хөрөнгийн түрээс болон богино хугацаат түрээсийн хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргыг сонгосон. Групп эдгээр түрээстэй холбоотой түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(n) Орлогын албан татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардлаас бүрддэг. Тайлант үеийн татвар болон хойшлогдсон татварыг өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдаар хүлээн зөвшөөрдөг.

(i) Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохицуулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдэж байсан эсвэл мөрдөгдэж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашигийг тооцоходоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (tatvarын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашигийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашигаас ялгаатай байдаг.

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг хөрөнгө, өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоор хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дун хөёрын хоорондох түр зөрүүнд үндэслэдэг.

Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг татвар ногдох орлого олсон үед татварын орлого ногдох нь тодорхой болсон бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед Групп хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдор болсон, эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (tatvarын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Групп нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөн буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

(n) Орлогын албан татвар (үргэлжлэл)

I рүпгр нь тайлант үеин татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцааг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

Хэрэв ногдол ашиг төлөлтгэй холбоотойгоор нэмэлт орлогын албан татварын зардал үүссэн бол уг орлогын албан татварын зардлыг ногдол ашгийн төлөлтгэй холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед орлогын албан татварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

(p) Сангууд

Группд өнгөрсөн үйл явдлын үр дунд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн байгаа энэхүү үүргээ билэлүүлэх нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийн санг хүлээн зөвшөөрөнө. Нөөцийн санд хүлээн зөвшөөрсөн дүн нь тайлагналын хугацааны эцэст одоогийн үүргийг билэлүүлэхэд шаарддагдах төлбөрийн хамгийн сайн тооцоолол бөгөөд үүрэгтэй холбоотой эрсдэл болон тодорхой бус зүйлсийг харгалзан үздэг.

Нөөцийн санг өнөөгийн үүрэг хариуцлагыг хангах мөнгөн урсгалыг ашиглан тооцоолсон үед түүний дансны дун нь эдгээр мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэ цэнэ болдог (мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн нөлөө нь материаллаг бол).

Хэрэв нөөцийн санг билэлүүлэхэд бүх эсвэл зарим эдийн засгийн үр өгөөж нь гуравдагч этгээдээс ирэх бол нохон олговор хүлээн авах нь тодорхой, мөн авлагын дүн нь найдвартай тооцоологдох боломжтой тохиолдолд авлагыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрөнө.

(c) Санхүүгийн баталгаа болон зээлийн амлалт

Санхүүгийн баталгаа гэдэг нь өрийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн дагуу төлбөрөө төлөөгүйгээс үүдэн баталгаа гаргуулагчийн өмнөөс баталгаа гаргагч буюу Групп өрийн хэрэглүүр эзэмшигчид төлбөрийг барагдуулах үүрэг бий болгож буй гэрээ. Зээлийн амлалт гэдэг нь урьдчилан тодорхойлсон нөхцөлийн дагуу зээл олгох хатуу амлалт юм.

Гаргасан санхүүгийн баталгаа эсвэл зах зээлийн ханшаас доогуур хүүтэй зээл олгох амлалтыг эхлээд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Дараа нь тэдгээрийг СТОУС 9-д заасны дагуу тодорхойлсон алдагдлын нөөц ба анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс СТОУС 15-ын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн орлогын хуримтлагдсан дүнг зохих тохиолдолд хасаж тооцно. Зээлийн амлалтын хувьд Групп алдагдлын нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн баталгаа болон зээлийн амлалтаас үүсэх өр төлбөрийг эрсдэлийн санд тусгана.

(m) Холбоотой талууд

Санхүүгийн тайлантай холбоотойгоор Группийн холбоотой талуудад дараах талууд багтана.

- (i) Группийг шууд эсвэл нэг буюу түүнээс дээш зуучлагчаар дамжуулан шууд бусаар хянадаг, санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын чанартай шийдвэрлийг гаргахад Группт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвартай, эсвэл Группийг хамтран хянадаг этгээд;
- (ii) Групптэй нэгдсэн нэг хяналтад байдаг этгээд болон оролцогч талууд нь нийтлэг хяналтад байдаг;
- (iii) Группийн эсвэл Группийн толгой Группийн гол удирдах ажилтан, эсвэл уг ажилтны гэр бүлийн ойр дотнын гишүүн, эсвэл уг ажилтны хяналтад байдаг, хамтарсан хяналтад эсвэл мэдэгдэхүйц нөлөөнд байдаг аж ахуйн нэгж;
- (iv) (i)-д дурдсан этгээдийн гэр бүлийн ойр дотнын гишүүн, эсвэл уг гишүүний хяналтад байдаг, хамтарсан хяналтад байдаг эсвэл мэдэгдэхүйц нөлөөнд байдаг аж ахуйн нэгж;
- (v) Группийн эсвэл Групптэй холбоотой аж ахуйн изгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төловлөгөөг хэрэгжүүлэгч этгээд.
- (vi) Хувь хүний гэр бүлийн ойр дотнын гишүүд гэдэг нь Групптэй ажил хэргийн харилцаанд орох явцад тухайн хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж магадгүй гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31

3. Нягтлан бodoх бүртгэлийн чухал тооцоолол болон үнэлэмж

Групп ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба таамаглал ашигладаг. Түүхэн туршлага болон Үссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хучин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг Ирээдүйл болит үр дун нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба таамаглалыг доор дурдлаа.

Үнэлэмжүүд

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бodoх бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдсэн үнэлэмжийн талаарх мэдээллийг доорх тодруулгуудад оруулсан:

- Тодруулга 2.4 г (vi), 7, 14 болон 36 (a); анхны хүлээн зөвшөөрлөөс хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн эрдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлох шалгуурыг тогтоох, ХБЗА-ийг хэмжилтэд ирээдүйг таамагласан мэдээллийг ашиглах аргачлалыг тодорхойлох, ХБЗА-ийг хэмжихэд ашиглагдах загварыг сонгон батлах.

Тооцоолол ба таамаглал

Дараагийн санхүүгийн жилд материаллаг залруулгад хүргэж болох нөлөөлөхүйц эрсдэлтэй таамаглал болон тооцооллын тодорхойгүй байдлын талаарх мэдээлэл дараах тодруулгад оруулсан болно.

- Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт – Тодруулга 13, 14, 15, 16 болон 36 (a)

4. Хүүгийн цэвэр орлого

	2024 мян.төг	2023 мян.төг
<i>УАХТ аргаар тооцсон хүүгийн орлого:</i>		
Харицагчдад олгосон зээл ба урьдчилгaa	222,149,196	124,434,889
Санхүүгийн хөрөнгө оруулалт	1,483,820	525,259
Банкинд байршуулсан хугацаатай хадгаламж	549,307	601,766
Банкин дахь харилцах	350,636	174,093
Нийт хүүгийн орлого	224,532,959	125,736,007
<i>УАХТ аргаар тооцсон хүү болон түүнтэй адилтгах зардал:</i>		
Зээлээр татсан санхүүжилт	(32,309,242)	(14,469,068)
Итгэлцэл	(30,136,641)	(21,667,456)
Бондын өр төлбөр	(18,052,643)	(9,285,547)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	(758,704)	(253,487)
Хоёрдогч өглөг	(345,597)	(426,131)
	(81,602,827)	(46,101,689)
<i>Бусад хүү болон түүнтэй адилтгах зардал:</i>		
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр, цэвэр	(1,931,318)	(636,792)
Нийт хүүгийн зардал	(83,534,145)	(46,738,481)
Хүүгийн цэвэр орлого	140,998,814	78,997,526

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Группийн эредэлийн удирдлагын зорилго, бодлогыг тодорхойлж түүнд үндсэн үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ, Группийн санхүүгийн үйл ажиллагааны зорилго, бодлогыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх горимыг боловсруулж, үйл ажиллагааг нь явуулах эрх мэдлийг санхүүгийн хэлтэст олгосон байдаг. Удирдлага нь Группийн санхүүгийн албанаас сар бүр тайлан авч тавьсан зорилго, бодлогын тохиромжтой байдал болон хэрэгжүүлж буй горимын үр дүнтэй байдлыг шалгадаг. Мөн Группийн дотоод аудитын нэгж эредэлийн удирдлагын бодлого, горимын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээ Аудитын хороонд танилцуулдаг.

Удирдлагын үндсэн зорилго нь Группийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд иөлөөлөхгүйгээр эредэлийг аль болох бууруулахад чиглэсэн бодлогыг тодорхойлох явдал юм. Эдгээр бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дор харуулав:

a) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь харилцагч эсвэл гэрээний негөө тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Группд санхүүгийн алдагдал учрах эрсдэл юм. Харилцагчид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, барьцаа хөрөнгийн үнэ цэнийн буурсан, барьцаа хөрөнгөөр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй зэргээс үүдэн зээлийн эрсдэлд голчлон өртөж байна. Группи нь зээлийн эрсдэлийн удирдлагыг нэгдсэн журмаар мэргэжлийн иэгжүүдийн хамтын эрх мэдэлтэйгээр Зээлийн эрсдэлийн хороогоор дамжуулан тогтмол хэлэлцэж шийдвэр гаргадаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар өндөр дунтэй болон өндөр эрсдэлтэй зээлийн асуудлыг хэлэлцидэг.

Группи нь зээлийн үйл ажиллагаанд ТУЗ-оос баталсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”, Зээлийн эрсдэлийн хорооноос баталсан “Зээлийн эрсдэлийн удирдлагын журам”-ыг баримталдаг. Бодлогын дагуу эрсдэлийн удирдлагын үйл явц нь дараах 5 үе шатаас бүрдэнэ.

1. Эрсдэлийг тодорхойлох ба илрүүлэх
2. Эрсдэлийн шинжилгээ ба хэмжилт
3. Эрсдэлийн үнэлгээ – Эрсдэлийн шинж чанарт тохирсон тоон болон чанарын үнэлгээний хандлага
4. Эрсдэлийн бууруулах болон арилгах арга хэмжээ
5. Тогтмол хяналт

Зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь зээлийн эрсдэлийг удирдахад хэрэглэгдэж буй зээлийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг баримтлах, зээлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл, хүлээгдэж буй өгөөжийг хамгийн оновчтой түвшинд байлгахад оршино.

Группи нь зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд дараах зарчмуудыг баримталдаг:

1. Зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх.
2. Зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоотой байх.
3. Зээл олголтын дараах хяналтыг хэрэгжүүлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх.
4. Зээлийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг авч үзэх.
5. Мэдээллийн нууцлалыг хамгаалах.
6. Ашиг сонирхлын зөрчилгүй байх.

Группи нь хувь хүн, хуулийн этгээдэд эрсдэлийн зөвшөөрөгдөх хэм хэмжээ, хязгаар тогтоо замаар зээлийн эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Группийн зүгээс зээлийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөх шалгуур зөрчигдөх магадлалтай нохцөл байдалд зээлдэгчийн хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрөө төлөх чадварыг шинжилж, үнэлэх замаар зээлийн эрсдэлийг удирдаж, хяналт тавьдаг. Зээлийн эрсдэлд өртөх байдлыг барьцаа хөрөнгө, хуулийн этгээд болон хувь хүний баталгаа гаргуулснаар мөн удирддаг.

36. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

а) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгааг тооцоололгүйгээр зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ

Зээлийн эрсдэл өртөх дээд хэмжээ	Тодруулга	2024	
		мян.төг	2023 мян.төг
Бэлэн болон банк дахь мөнгө	13	135,287,651	81,915,363
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	14	764,734,525	502,622,704
БҮЦБДО-оор илэрхийлэгдэх өрийн	15	18,260,381	3,818,532
Бусад санхүүгийн хөрөнгө	16	3,983,923	4,224,144
Нийт балансын гадуур		922,266,480	592,580,743
Үүрэг	35	24,248,881	9,084,595
Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн		946,515,361	601,665,338

Зээлийн чанарын шинжилгээ

Группийн дотоод зээлийн зэрэглэлд үндэслэн хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарын талаарх мэдээллийг дараах хүснэгтэд харуулав. Санхүүгийн хөрөнгийн хувьд тусгайлан заагаагүй бол хүснэгт дэх дун нь дансны нийт дүнг илэрхийлнэ.

"Түвшин 1", "Түвшин 2", "Түвшин 3" гэсэн нэр томъёоны тайлбарыг Тодруулга 2.4(r)(vi)-д оруулсан.

	ТТБМ хүрээ	2024			Нийт мян.төг
		Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	
Хэвийн	0.02-4.8%	854,544,428	–	–	854,544,428
Хугацаа хэтэрсэн	3%-71.3%	–	27,428,633	–	27,428,633
Хэвийн бус	100%	–	–	13,041,311	13,041,311
Эргэлзээтэй	100%	–	–	18,344,711	18,344,711
Муу	100%	–	–	12,305,950	12,305,950
Хойшлогдсон хураамж		(3,140,774)	(107,409)	(150,370)	(3,398,553)
Нийт дүн		851,403,654	27,321,224	43,541,602	922,266,480
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга		(8,489,356)	(1,678,545)	(22,470,224)	(32,638,125)
Цэвэр дүн		842,914,298	25,642,679	21,071,378	889,628,355

	ТТБМ хүрээ	2023			Нийт мян.төг
		Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	
Хэвийн	0.02-3.7%	560,087,305	–	–	560,087,305
Хугацаа хэтэрсэн	3%-70.4%	–	13,791,533	–	13,791,533
Хэвийн бус	100%	–	–	5,311,430	5,311,430
Эргэлзээтэй	100%	–	–	7,340,578	7,340,578
Муу	100%	–	–	8,286,484	8,286,484
Хойшлогдсон хураамж		(2,150,691)	(65,228)	(20,668)	(2,236,587)
Нийт дүн		557,936,614	13,726,305	20,917,824	592,580,743
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга		(5,372,270)	(1,318,728)	(11,294,371)	(17,985,369)
Цэвэр дүн		552,564,344	12,407,577	9,623,453	574,595,374

36. Санхүүгийн хэрэглүүр – Эрдэлийн удирдлага (үргэлжлэл)

a) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүссэн дүн

Групп нь зээлийн эрсдэлийг бууруулахын тулд зээлд хангалттай барьцааг шаарддаг ба зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлдэгчдээс барьцаа хөрөнгө шаарддаг. Барьцаа хөрөнгийн стандарт, шаардлага, хүлээн зөвшөөрөх төрлүүдийг барьцаа хөрөнгийн журамдаа тодорхой заасан байдаг. Барьцаа хөрөнгө нь зээлийн бүтээгдэхүүнээс хамаарч өөр өөр байдаг, тухайлбал, бизнесийн зээлийн хувьд хөдлөх болон ул хөдлөх хөрөнгө барьцаалах, харин хэрэглээний зээлийн хувьд ихэвчлэн тухайн зээлээр худалдан авч буй цахилгаан хэрэгсэл, жижиг тоног төхөөрөмж эсвэл бусад эд хөрөнгийг барьцаалдаг.

Покет платформоор дамжуулан олгож буй дижитал зээлийн хувьд групп зээлдэгчийн зээлийн скоринг онооны загвар тулгуурлан шийдвэр гаргадаг бөгөөд барьцаа хөрөнгө шаарддаггүй.

Зээлийн барьцаа хөрөнгө

Групп нь зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгийг хадгалдаг. Доорх хүснэгтэд санхүүгийн хөрөнгийн төрөл бүрийн ангилалд холбогдох голлох барьцааны төрлүүдийг харуулав.

ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниуд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн хэрэглүүр – Эрдэлийн удирдлага (үргэлжлэл)

а) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Барьцаа
хоронгийн
торол

Зээлийн барьцаа хоронгийн бодит үзүүр

Багцад хамаарах
барьцаа
хоронгийн
шаардлагын
хувь
Үзүүлийн
бууралтын
хаасагдуулга

2024 оны 12-р сарын 31	Зээлийн эрсдэлд ортож болох ийн багц	Үл ходлох хоронго	Бараа материал	Тээврийн хэрэгсэл	Хадгаламж	Бусад санхүүгийн хэрэгжүүрүүд	Тоног тохөөрөмж	Бусад	Ийн барьцаа	Ортолж болох иёвэр багц	Мянгийн төгрөг	Мянгийн төгрөг
	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг	мянгийн төгрөг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа												
Дижитал зээл	247,320,287	1,743,118	–	51,449,998	–	–	40,929,197	60,000	94,182,313	153,137,974	38%	12,078,462
Хэрэглээний зээл	205,388,061	188,413,083	5,841,296	630,166,047	3,519,469	2,298,889	4,100,995	772,000	835,111,779	–	100%	4,557,766
Барилгын зээл	60,755,770	164,055,613	–	23,904,817	–	6,291,572	395,000	90,000	194,737,002	–	100%	7,831,897
Санхүү, даатгалын зээл	2,738,355	577,102	–	626,470	10,000	39,667,177	142,000	–	41,022,749	–	100%	4,598,877
Бөөний болон жижиглэгэнгийн худалдааны зээл	36,254,203	22,533,916	1,447,185	44,439,438	54,079	136,700	3,289,000	100,000	72,000,318	–	100%	195,456
Бусад зээл	208,307,927	133,636,300	4,017,949	243,414,489	–	2,431,699	161,220,754	532,000	545,253,191	–	100%	2,467,152
Үл ходлох хоронгийн зээл	3,969,922	2,851,364	–	528,700	–	4,377,358	130,000	–	7,887,422	–	100%	27,445
Нийт	764,734,525	513,810,496	11,306,430	994,529,959	3,583,548	55,203,395	210,206,946	1,554,000	1,790,194,774	–	100%	31,757,055

2023 оны 12-р сарын 31

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа												
Дижитал зээл	116,181,662	–	–	–	–	–	–	–	–	116,181,662	0%	6,454,925
Хэрэглээний зээл	65,828,527	23,547,022	9,775,344	100,026,479	153,000	288,260	5,171,495	705,000	139,666,600	–	100%	1,487,618
Барилгын зээл	39,224,104	108,126,077	–	25,923,374	–	341,069	305,000	102,000	134,797,521	–	100%	1,835,114
Санхүү, даатгалын зээл	2,627,822	776,400	–	1,140,500	–	28,998,288	447,000	–	31,362,188	–	100%	254
Бөөний болон жижиглэгэнгийн худалдааны зээл	55,202,343	28,312,650	3,097,612	67,181,090	820,000	1,693,736	5,517,033	535,000	107,157,120	–	100%	3,187,271
Бусад зээл	222,385,403	84,367,924	3,444,606	224,931,165	512,726	6,788,630	101,354,341	1,119,000	422,518,392	–	100%	4,737,328
Үл ходлох хоронгийн зээл	1,172,843	1,861,252	–	822,700	–	–	130,000	–	2,813,952	–	100%	31,236
Нийт	502,622,704	246,991,325	16,317,562	420,025,308	1,485,726	38,109,983	112,924,869	2,461,000	838,315,773	–	100%	17,733,746

36. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

a) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Зээлийн барьцаа нь зөвхөн үндсэн төлбөр болон үндсэн зээл дээр хуримтлагдсан хүүг төдийгүй эрсдэлтэй зээлийн хувьд нэмэгдүүлсэн хүү зэргийн төлж барагдуулахад хангалтай байх ёстой. Барьцаа хөрөнгийн стандарт үнэлгээний арга, зах зээлийн харьцуулалтын арга, орлого болон ортгийн арга зэрэг аргуудыг үндэслэн үнэлж, түүний дагуу зах зээлийн үнийг тодорхойлж үнэлдэг. Удирдлага нь барьцаа хөрөнгийн үнэ цэнийг хянадаг.

Үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашигладаг мэдээлэл, таамаглал, аргачлал

Групп нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ СТОУС 9-ийн 3 шатлалын аргачлалыг ашигладаг. Хүлээгдэж буй зээлийн хохирлыг хамтад нь үнэлхэн тулд зээлийн авлагыг ижил төстэй зээлийн эрсдэл болон наасжилтаар бүлэглэдэг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг долоон жилийн түүхэн мэдээлэл болон тухайн жилийн мэдээлэлд үндэслэн тооцоолно. Алдагдал үүсэх магадлалыг бодит болон ирээдүйд чиглэсэн макро эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан тооцдог. Групп нь хүлээгдэж буй зээлийн алдагдалыг тооцоход ДНБ-ий өсөлт, нүүр болон зэсийн үнийн өөрчлөлт, Монгол банкны бодлогын хүү зэрэг макро хүчин зүйлсийг голчлон авч үздэг.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүүц өсөлт

Санхүүгийн хэрэглүүрийг анх бүртгэнээс хойш зээлд төлбөр төлөхгүй байх эрсдэл мэдэгдэхүүц нэмэгдсэн эсэхийг тодорхойлоходо тоон болон чанарын мэдээлэл, шинжилгээ, группийн түүхэн туршлага, зээлийн мэргэшсэн үнэлгээ, ирээдүйд чиглэсэн мэдээллийг авч үздэг.

Зээлийн эрсдэл мэдэгдэхүүц нэмэгдсэн эсэхийг тодорхойлохын тулд групп дараах гурван шалгуурыг ашигладаг:

- Чанарагүйдэлд өртөх дүн (ЧӨД)-гийн өөрчлөлтөд үндэслэсэн тоон шалгуур;
- Чанаарын үзүүлэлтүүд;
- Нооц шалгуур үзүүлэлт: хэрэв төлбөрийн хугацаа 30-аас дээш хоног хугацаа хэтэрсэн, эсвэл дахин бүтэцлэгдсэн бөгөөд дотоод болон гадаад үнэлгээ хоёр ба түүнээс дээш шатлалаар буурсан бол тухайн санхүүгийн хөрөнгийг 2-р түвшинд ангилна; харин төлбөрийн хугацаа 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн бөгөөд зөрчилд орсон бол 3-р түвшинд ангилна.

Зээлийн эрсдэлийн зэрэглэл

Групп нь зээлдэгчийн эрсдэлийг урьдчилан таамаглах боломжтой мэдээлэл, зээлийн үнэлгээний үндсэн дээр эрсдэлийн ангилалд тус бүрийг багцад байршуулдаг. Эрсдэлийн ангиллуудыг эрсдэлийн үндсэн шалтгаантай холбоотой чанарын болон тоон үзүүлэлтүүдээр тодорхойлно.

Зээлийн эрсдэлийн багцыг анх бүртгэхдээ зээлдэгчтэй холбоотой мэдээллийг үндэслэн зээлийн эрсдэлийн зэрэглэлд ангилагддаг. Тухайн багцыг өөр эрсдэлийн ангилалд шилжиж байгаа эсэхийг тогтмол хянаж шалгадаг. Хянах үйл нь дараах тодорхой мэдээллийг ашиглан хийгддэг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлоходо зээлдэгчийн санхүүгийн байдал, зээлийн ашиглалт, гэрээний бүтцийн өөрчлөлт, эргэн төлөлтийн түүх, орлогын тогтвортой байдал, эдийн засгийн хөдөлгөөн, хууль хяналтын байгууллагын тодорхойлолт зэргийг харгалзан үздэг.

- Хэрэглэгчийн зан төлөвийн талаарх группийн дотооддоо цуглуванс мэдээлэл – жишээлбэл, зээлийн картын ашиглалт
- Зээлийн мэдээллийн сангаас авсан мэдээлэл
- Эргэн төлөлтийн мэдээлэл – үүнд хугацаа хэтэрч байсан байдал, төлбөрийн харьцааны талаарх мэдээлэл
- Өмнөх зээлийн ашиглалт
- Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах хүсэлт
- Бизнес, санхүү, эдийн засгийн нөхцөл байдалд одоо байгаа болон таамагласан өөрчлөлтүүд

Зээлийн эрсдэл мэдэгдэхүүц өссөн эсэх

Групп нь зээлийн эрсдэлийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш эрсдэл мэдэгдэхүүц хэмжээнд өссөн эсэхийг тайлант үе бүрт үнэлдэг. Зээлийн эрсдэл ихэссэн эсэхийг тодорхойлох нь санхүүгийн хэрэглүүр болон зээлдэгчийн онцлогоос хамаарна.

Зээлийн эрсдэл нь анх бүртгэнээс хойш мэдэгдэхүүц хэмжээд өссөн гэж үзэх үндэслэл нь группийн зээлийн эрсдэлийг удирдах үйл ажиллагаатай холбоотой чанарын хүчин зүйлүүд дээр үндэслэж болох ба эдгээр нь тоон шинжилгээнд шууд тусгагдаагүй байж болзошгүй. Энэ нь өндөр эрсдэлдэлтэй зээлийн шалгуур хангасан буюу анхаарал татсан зээлийн жагсаалтад орсон зээлүүдэд хамааралтай.

Эдгээр чанарын хүчин зүйлүүд нь Группийн зээлийн эрсдэлийн шинжээчдийн дүгнэлт, холбогдох түүхэн туршлага дээр суурилдаг.

36. Санхүүгийн хэрэглүүр – Эредэлийн удирдлага (үргэлжлэл)

a) Зээлийн эрдэл (үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашигладаг мэдээлэл, таамаглал, аргачлал (үргэлжлэл)

Зээлийн эрдэлийн мэдэгдэхүүц өссөн эсэх (үргэлжлэл)

Зээлийн төлбөр 30 хоногоос дээш хугацаанд төлөгдөөгүй тохиолдолд Групп зээлийн эрдэл мэдэгдэхүүц хэмжээнд өссөн гэж үздэг. Хугацаа хэтэрсэн хоногуудыг төлбөрийн хуваарь анх зорчигдсөн өдрөөс хойших буюу төлбөрийг бүрэн аваагүй өдрүүдийг тоолох замаар тодорхойлоно. Үндээн төлбөрийн хэтэрсэн хугацааг зээлдэгчид олгосон хонгөлөлтийн хугацааг тооцолгүйгээр тогтооно.

Анх хүлээн зөвшөөрсөнтэй харьцуулахад зээлийн эрдэл мэдэгдэхүүц нэмэгдэхээ больсон гэдгийг нотлох баримт байгаа бол санхүүгийн хэрэглүүрийн алдагдлын нөөцийг 12 сарын ХБЗА болгон хэмжинэ. Зээлийн эрдэлийн өсөлтийн зарим чанарын үзүүлэлтүүд, тухайлбал, алдагдалд орох эрдэл нэмэгдэж байгааг илтгэж болно. Зээлийн гэрээний нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд, тухайн зээлийн нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хангахаа больсон эсэхийг тодорхойлох нотолгоонд шинэчлэгдсэн гэрээний нөхцөлийн дагуу хугацаанд нь төлөлт хийсэн түүх хамаарна.

Групп нь зээлийн эрдэлийн мэдэгдэхүүц өсөлтийг тодорхойлоход ашигласан шалгуур үзүүлэлтүүдийн үр нөлөөг тогтмол хянах замаар дараах зүйлийг баталгаажуулдаг.

- шалгуур үзүүлэлтүүд нь зээлийн эрдэлд өргөхөөс өмнө мэдэгдэхүүц өсөлтийг тодорхойлох чадвартай байх;
- шалгуур үзүүлэлт нь хөрөнгийн хугацаа 30 хоног хэтэрсэн хугацаатай таарахгүй байх;
- Зээлийн эрдэлийн мэдэгдэхүүц өсөлтийг тодорхойлох болон төлөгдөхгүй байх хоорондох дундаж хугацаа үндэслэлтэй байх;
- эрдэлийг 12 сарын ХБЗА хэмжилтээс шууд зээлийн үнэ цэнийн бууралтад шилжүүлдэггүй; болон 12 сарын хугацаатай ХБЗА (түвшин 1) болон тухайн зээлийн нийт хугацаа ХБЗА (түвшин 2) хооронд шилжилт хийх үед алдагдлын нөөцөд үндэслэлгүй хэлбэрэлэл үүсэхгүй байх.

Төлбөр төлөхгүй байх эрдэл

Групп нь дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг төлөхгүй байх эрдэлтэй гэж үздэг:

- Төлбөрийн чадваргүй байдал: Зээлдэгчийг дараах шалтгаанаар төлбөрийн чадваргүйд тооцно.
 - Санхүүгийн нөхцөл байдал нь мэдэгдэхүүц муудсан
 - Хүү эсвэл үндсэн төлбөрийг төлөхөд хүндэр учирсан
 - Үүрэг гүйцэтгэгч дампуурал эсвэл бусад санхүүгийн бүтцийн өөрчлөлтөд орох магадлалтай
- 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн.

Зээлдэгчийг төлбөр төлөхгүй байх эрдэлтэй эсэхийг үнэлэхдээ Групп дараах үзүүлэлтүүдийг харгалzan үздэг.

- чанарын үзүүлэлтийн хувьд - жишээ нь гэрээний нөхцөл зөрчсөн;
- тоон үзүүлэлтийн хувьд – тухайлбал, өөр этгээдийн өмнө хүлээсэн үүргийн хувьд хугацаа хэтэрсэн байдал, төлөгдөөгүй байдал; болон
- дотоод болон гадаад эх сурвалжаас олж авсан мэдээлэлд үндэслэнэ.

Санхүүгийн хэрэглүүрийн төлбөр төлөхгүй байх эрдэлтэй эсэхийг үнэлэхдээ ашиглагдах мэдээллийд болон тэдгээрийн ач холбогдол нь нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан цаг хугацааны явцад өөр байж болно.

Ирээдүйг таамагласан мэдээллийг ашиглах

Групп нь зээлийн эрдэлийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрдэл мэдэгдэхүүц хэмжээнд өссөн эсэхийг үнэлэх болон ХБЗА-ыг хэмжихэд ирээдүйг таамагласан мэдээллийг ашигладаг. Зээлийн эрдэлийн гол хүчин зүйлс нь: ДНБ-ий өсөлт, ажилгүйдлийн түвшин, хүүгийн түвшин зэрэг юм. Группийн зээлийн багцын дундаж хугацаа богино байdag тул эдээр гол хүчин зүйлсийн нөлөөлөл нь ач холбогдол багатай байдаг.

Бутцийн өөрчлөлтөд орсон санхүүгийн хөрөнгүүд

Зээлийн гэрээний нөхцөлүүдийг өөрчлох нь тухайн зээлдэгчийн одоогийн болон ирээдүйн зээлийн чанар муудахтай холбоогүй, зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөх, харилцагчийг хадгалах зэрэг олон шалтгаанаар хийгдэж болдог. Хугацаа хэтрээгүй, бүтэц өөрчлөөгүй зээлийг 1-р түвшинд ангилна. Хугацаа 90 хоног хүртэл хэтэрсэн болон бүтэц өөрчилсөн зээлийг 2-р түвшинд ангилна. Хугацаа 90 хоногоос дээш хэтэрсэн эсвэл ХБЗА үүссэн зээлийг 3-р түвшинд ангилна.

**ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31**

36. Санхүүгийн хэрэглүүр – Эредэлийн удирдлага (үргэлжлэл)

a) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хүлээгдээж буй зээлийн алдагдлын хэмжсилт

ХБЗА-ний хэмжээг тооцоход дараах хувьсагчдыг ашиглана:

- Толбор толгөхгүй байх магадлал (ТТБМ);
- Алдагдал үүсэх магадлал (АҮМ);
- Чанартгүйдэл өртөх дүн (ЧӨД).

1-р түвшний ХБЗА-ыг 12 сарын ТТБМ-ийг АҮМ болон ЧӨД-ээр үргүүлж тооцно.

Зээлийн нийт хугацааны ТТБМ-ийг нийт хугацааны ТТБМ-ийг АҮМ болон ЧӨД-ээр үргүүлнэ.

АҮМ нь төлбөр төлөх боломжгүй байдлаас үүсэх алдагдлын тооцоолол юм. АҮМ-ын загвар нь санхүүгийн хөрөнгийн бүтэц, барьцаа хөрөнгө, иехэмжлэлийн хугацаа, гэрээлэгч талын үйл ажиллагаа явуулж буй салбарын онцлог болон барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулахтай холбоотой зардлыг харгалзан үздэг. АҮМ-ын тооцооллыг эдийн засгийн өөр өөр хувилбаруудад тохируулсан байдаг. Эдгээрийг үр ашигт хүүгийн түвшнийг хөнгөлөлтийн хүчин зүйл болгон ашиглаж хөнгөлсөн мөнгөн гүйлгээний аргаар тооцоолдог.

ЧӨД нь төлбөр төлөх боломжгүй үед хүлээх боломжит өртөлтийг илэрхийлнэ. Групп ЧӨД-г гэрээлэгч талын одоогийн өр төлбөр болон гэрээний хүрээнд зөвшөөрөгдсөн дүнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдоос үүсэх боломжит өөрчлөлтүүдийг үндэслэн тодорхойлдог. ЧӨД нь өнөөгийн үнэ цэнээр хэмжигддэг. ЧӨД нь санхүүгийн хөрөнгийн хугацаа хэтэрсэн үеийн нийт дансны үлдэгдэл дүнтэй тэнцүү байна. Зээлийн үүргийн хувьд ЧӨД нь гэрээний дагуу ирээдүйд олж авах боломжтой дүн бөгөөд үүнийг түүхэн мэдээлэл болон ирээдүйн төсөөлөлд үндэслэн тооцдог. Санхүүгийн баталгааны хувьд, ЧӨД нь санхүүгийн баталгаа төлөгдөх үед гарах дүнг илэрхийлдэг.

Дээр дурдсанчлан, мөн 1-р түвшний санхүүгийн хөрөнгийн хувьд дээд тал нь 12 сарын ТТБМ ашиглах нөхцөлд, Групп нь зээлийн эрсдэлд өртөж болох гэрээний хамгийн урт хугацааг (зээлдэгчийн сунгах боломжийг оруулаад) үндэслэн ХБЗА-г тооцоолдог. Гэрээний хамгийн дээд хугацаа нь компани урьдчилгаагаа төлөхийг шаардах, зээлийн үүрэг, баталгааг цуцлах эрхтэй өдөр хүртэл үргэлжилнэ.

b) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь групп хүүтэй, арилжаалагдах болон гадаад валютын санхүүгийн хэрэглүүрийг ашигласнаас үүдэн үүсдэг. Энэ нь хүүгийн хувь хэмжээ (хүүгийн түвшний эрсдэл), валютын ханш (гадаад валютын ханшийн эрсдэл) болон бусад зах зээлийн хүчин зүйлсийн (бусад зах зээлийн үйний эрсдэл) өөрчлөлтөөс шалтгаалж санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ өөрчлөгдхөө эрсдэл юм.

i) Хүүгийн түвшиний эрсдэл

Групп хүүгийн эрсдэлийг хүүгийн хувь болон түүний тооцоолж буй хэлбэлзлийн сөрөг өөрчлөлтөөс үүсэх боломжит алдагдал гэж тодорхойлдог. Группийн зээл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хүүгийн эрсдэлийг бий болгодог. Зээлийн хүүгийн өөрчлөлтийн шууд нөлөөлөл нь группийн цэвэр хүүгийн орлогод нөлөөлдөг бол урт хугацааны нөлөөлөл нь группийн хөрөнгө, өр төлбөр, балансаас гадуурх эрсдэлийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлне. Группийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь хүүгийн түвшний өөрчлөлт нь группийн хүлээн зөвшөөрөх хүүгийн түвшний эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээтгэй хэрхэн нийцэж байгааг тогтмол хянаж байдаг.

Дараах хүснэгт нь бүх бусад хувьсагчид тогтмол байхад хүүгийн хувь хэмжээнд боломжит өөрчлөлтөөс группийн орлогын тайланд үзүүлэх мэдрэмжийг харуулсан. Орлогын тайлангийн мэдрэмж нь 2024 оны 12-р сарын 31 болон 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар эзэмшиж буй хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дагуу хүүгийн хувь хувьсах өөрчлөлтийн нөлөөг нэг жилийн хугацаанд сөрөг болон эргээр тооцсон өр төлбөрийн орлогын нөлөөллөөр тодорхойлогддог.

Хүүгийн авлага, өр төлбөрийн хэмжээ, холбогдох хүүгийн хэмжээг доор харуулав.

Иэгж өөрчлөлт	Валют	Цэвэр хүүгийн зардлын мэдрэмж	
		2024 мян.төг	2023 мян.төг
Зээлээр авсан санхүүжилт	+/-100	ам.доллар	+/-1,048,877
			+/-750,352

ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниуд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн хэрэглүүр – Эрдэлийн удирдлага (үргэлжлэл)

i) Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

ii) Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан хэлбэлзэх эрсдэл юм. Энэ эрсдэл нь гадаад валютын гүйлгээ болон гадаад валютаар илэрхийлэгдсэн хүлээн зөвшөөрөгдсэн хөрөнгө, өр толбөрөөс үүсдэг.

12 дугаар сарын 31-ний байдлаар, компанийн гадаад валютын эрсдэлд өртөж болох үзүүлэлт дараах байдалтай байна:

12-р сарын 31-нээр	Ам.доллар		Иен		Евро		Бусад		Нийт	
	2024 мян.тог	2023 мян.тог	2024 мян.тог	2023 мян.тог	2024 мян.тог	2023 мян.тог	2024 мян.тог	2023 мян.тог	2024 мян.тог	2023 мян.тог
Санхүүгийн хөрөнгө										
Бэлэн ба банк дахь мөнгө	47,897,624	1,951,521	3,335,564	15,142,491	1,394,165	74	3,336,954	2,434,821	55,964,307	19,528,907
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,618,154	14,635,756	803,748	–	–	–	59,693,525	31,842,092	63,115,427	46,477,848
БҮЦБДО-р илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө	18,260,381	3,818,532	–	–	–	–	–	–	18,260,381	3,818,532
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	16,497,242	13,241,400	8,603,280	–	–	–	–	–	25,100,522	13,241,400
Бусад санхүүгийн хөрөнгө	–	–	–	–	–	–	52,614	954,329	52,614	954,329
Санхүүгийн нийт хөрөнгө	85,273,401	33,647,209	12,742,592	15,142,491	1,394,165	74	63,083,093	35,231,242	162,493,251	84,921,016
Санхүүгийн өр толбор										
Зээлээр авсан санхүүжилт	124,360,400	60,540,580	–	2,911,100	1,837,069	554,110	18,851,984	14,296,493	145,049,453	78,302,283
Бондын оглог	–	–	–	–	–	–	7,107,069	613,888	7,107,069	613,888
Итгэлцэя	3,482,329	2,874,606	6,994,911	–	–	530,312	–	–	10,477,240	3,404,918
Түрээсийн өр толбор	–	–	–	–	–	–	263,599	448,015	263,599	448,015
Санхүүгийн нийт өр толбор	127,842,729	63,415,186	6,994,911	2,911,100	1,837,069	1,084,422	26,222,652	15,358,396	162,897,361	82,769,104
Цэвэр дүн	(42,569,328)	(29,767,977)	5,747,681	12,231,391	(442,904)	(1,084,348)	36,860,441	19,872,846	(404,110)	1,251,912

35. Санхүүгийн хэрэглүүр – эредэлийн удирдлага (үргэлжлэл)**б) Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)****ii) Гадаад валютын эрсдэл**

Дараах хүснэгтэд валютын ханш өөрчлөгдөхөд мөнгөөр илрхийлэгдлэг хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дунд орох өөрчлөлт нь Группийн татварын өмнөх ашиг болон өөрийн хоронгийн дунд ямар нөлөө үзүүлэхийг харуулсан.

	Татварын өмнөх ашигийн нолоо	
	2024 мян.тог	2024 мян.тог
Ам.доллар 20%-наар чангасан үед (2023: 20%)	(8,513,866)	(5,953,595)
Ам.доллар 20%-наар суларсан үед (2023: 20%)	8,513,866	5,953,595
Евро ханш 20%-наар чангасан үед (2023: 20%)	(88,581)	(216,870)
Евро ханш 20%-наар суларсан үед (2023: 20%)	88,581	216,870
Иен ханш 20%-наар чангасан үед (2023: 20%)	1,149,536	2,446,278
Иен ханш 20%-наар суларсан үед (2023: 20%)	(1,149,536)	(2,446,278)
Бусад ханш 20%-наар чангасан үед (2023: 20%)	7,372,088	3,974,569
Бусад ханш 20%-наар суларсан үед (2023: 20%)	(7,372,088)	(3,974,569)

в) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл нь Группийн санхүүгийн үүргээ хугацаандаа биелүүлж чадахгүй байх эрсдэл юм. Энэ нь Групп санхүүгийн үүргээ биелүүлэхэд хүндэрл тулгарах магадлалыг харуулдаг.

Группийн бодлого нь санхүүгийн үүргээ хугацаандаа биелүүлэхэд хангалттай мөнгөн хөрөнгөтэй байхыг баталгаажуулах явдал юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд групп нь шаардлагатай үед үүргээ биелүүлэхэд хангалттай мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (Эсвэл тохиролцсон хөнгөлөлтүүд) хадгалахыг зорьдог.

Хөрвөх чадварын эрсдэл нь группийн мөнгөн гүйлгээг удирдах чадвараас үүдэлтэй. Групп нь жилийн төсвөө бэлтгэхдээ мөнгөн гүйлгээний хэрэгцээгээ үнэлдэг. Групп нь сар бүрийн хөрвөх чадварын эрсдэлийн үнэлгээ хийж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, цаашдын үйл ажиллагааг төлөвлөдөг.

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар санхүүгийн хөрөнгүүд болон санхүүгийн өр төлбөрүүдийг аливаа нэг хөнгөлөлтгүй гэрээний мөнгөн урсгалын дагуу эргэн төлөх үүргүүдэд үндэслэн харууллаа. Үүнд санхүүгийн хэрэглүүрийн хугацааны турш хуримтлагдах хүү орно. Хуулийн дагуу ногдох орлогын албан татварын дунг доорх хүснэгтэд тусгаагүй болно.

2024 оны 12-р сарын 31-нээр	3 сар хүртэл мян.тог	3-12 сар мян.тог	1-2 жил мян.тог	2-5 жил мян.тог	5-аас дээш жил мян.тог	Нийт мян.тог
Санхүүгийн хөрөнгө						
Бэлэн ба банк дахь мөнгө	131,286,651	4,001,000	–	–	–	135,287,651
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	177,997,738	286,336,868	402,217,113	269,977,393	18,602,699	1,155,131,811
БҮЦБДО-р илрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	4,718,820	17,980,474	–	–	–	22,699,294
Бусад санхүүгийн хөрөнгө	3,896,351	87,572	–	–	–	3,983,923
Санхүүгийн нийт хөрөнгө	317,899,560	308,405,914	402,217,113	269,977,393	18,602,699	1,317,102,680
Санхүүгийн өр төлбөр						
Зээлээр авсан санхүүжилт	81,171,198	167,300,359	102,617,153	46,268,521	–	397,357,231
Бондын өглөг	12,645,344	97,052,311	28,698,141	7,199,812	–	145,595,608
Хоёрдогч өглөг	–	850,000	850,000	–	–	1,700,000
Итгэлцэл	60,875,233	164,100,407	753,600	–	–	225,729,240
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	15,031,760	2,280,167	4,560,333	–	–	21,872,260
Бусад санхүүгийн өр төлбөр	8,698,458	–	–	–	–	8,698,458
Түрээсийн өр төлбөр	315,595	935,984	1,155,174	1,477,646	–	3,884,399
Санхүүгийн өр төлбөр	178,737,588	432,519,228	138,634,401	54,945,979	–	804,837,196
Цэвэр дүн	139,161,972	(124,113,313)	263,582,712	215,031,414	18,602,699	512,265,484

36. Санхүүгийн хэрэглүүр – Эрдээлийн удирдлага (үргэлжлэл)**в) Хорвох чадварын эрсдэл (үргэлжлэл)**

2023 оны 12-р сарын 31-нээр	3 сар хүртэл	3-12 сар	1-2 жил	2-5 жил	5-аас дээш жил	Нийт
	мян.тог	мян.тог	мян.тог	мян.тог	мян.тог	мян.тог
Санхүүгийн хөрөнгө						
Бэлэн ба банк дахь монго	71,591,755	10,840,133	–	–	–	82,431,888
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	121,402,894	201,213,762	226,149,712	194,426,904	112,446	743,305,718
БҮЦБДО-р илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	3,768,733	4,079,482	–	–	–	7,848,215
Бусад санхүүгийн хөрөнгө	4,224,144	–	–	–	–	4,224,144
Санхүүгийн иййт хөрөнгө	200,987,526	216,133,377	226,149,712	194,426,904	112,446	837,809,965
Санхүүгийн өр толбор						
Зээлээр авсан санхүүжилт	81,886,677	88,119,905	59,856,267	13,955,123	–	243,817,972
Бондын өглөг	5,067,951	68,590,261	944	–	–	73,659,156
Хоёрдогч өглөг	–	850,000	1,700,000	–	–	2,550,000
Итгэлцэл	24,163,842	119,156,568	4,172,532	–	–	147,492,942
Үүсмэл санхүүгийн өр толбор	171,222	517,429	509,899	168,084	–	1,366,634
Бусад санхүүгийн өр толбор	7,551,574	–	–	–	–	7,551,574
Түрээсийн өр толбор	192,827	568,466	741,166	1,262,304	–	2,764,763
Санхүүгийн өр толбор	119,034,093	277,802,629	66,980,808	15,385,511	–	479,203,041
Цэвэр дүн	81,953,433	(61,669,252)	159,168,904	179,041,393	112,446	358,606,924

г) Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хүний алдаа, залилан мэхлэлт, гаднын үйл явдлаас үүдэн гарах алдагдлын магадлал юм. Хяналт хангалтгүй зэвэл амжилтгүй болох үед үйл ажиллагааны зөрчил нь нэр хундэд хохирол учруулж, хууль эрх зүйн болон зохицуулалтын үр дагаварт хүргэж, санхүүгийн алдагдалд хүргэж болзошгүй юм. Групп нь үйл ажиллагааны бүх эрдээлийг арилгаж чадахгүй ч давхар хяналтын тогтолцоо, хамгаалалтын нэгдүгээр бүс болон арын албаны чиг үүргүүдийн хооронд үүрэг хариуцлагыг тусгаарлах, системд хяналтай нэвтрэх, зөвшөөрөл олгох болон үйл ажиллагаануудыг зохицуулсан журмууд, ажилтнуудын мэдлэг, үнэлгээний үйл явц зэргээр дамжуулан үйл ажиллагааны эрсдэлийг удирдаж, бууруулахыг эрмэлздэг.

Капиталын тодруулга

Групп мөнгөн ургалын хейджийн нөөцөөс бусад өмчийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (Энгийн хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, хяналтын бус хувь оролцоо, хуримтлагдсан ашиг ба дахин үнэлгээний нөөц гэх мэт) ‘тохируулсан капитал’-д хяналт тавьдаг. Группийн капиталын удирдлагын үндсэн зорилгууд нь:

- Хувьцаа эзэмшигч болон хувь ийнлүүлэгчдэд үргэлжлүүлэн өгөөж өгөхийн тулд группийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, болон
- Эрдээлийн түвшинд үндэслэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг тогтоо замаар хувьцаа эзэмшигчдэд зохих үр өгөөж өгөх.

Групп нь шаардлагатай капиталын дүнг холбогдох эрсдэлтэй нь уялдуулан тогтоодог. Групп капиталын бүтцийг удирдаж, зохих тохируулгыг хийхдээ эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт болон тухайн хөрөнгийн эрдээлийн шинж чанарыг авч үздэг. Капиталын бүтцийг тогтвортжуулах эсвэл түүнд тохируулга хийх тулд Групп ногдол ашиг болон капиталын өгөөжийн дүнд тохируулга хийх, шинэ хувьцаа гаргах эсвэл өр төлбөрөө бууруулах зорилгоор хөрөнгө борлуулах арга хэмжээ авч болно.

37. Бодит үнэ цэнийн тодруулга

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүр

Групп нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ зах зээл дээрх хамгийн сайн ажиглагдах боломжтой мэдээллийн ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ашиглаласан мэдээллийд дээр үндэслэн дараах түвшинээр ангилдаг.

Түвшин 1: Ижил төстэй хөрөнгө эсвэл өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ

Түвшин 2: Тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд 1 дүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад өгөгдлүүд, шууд (ж.нь үнэ) эсвэл шууд бусаар (ж.нь үнээс хамааралтай)

Түвшин 3: Хөрөнгө эсвэл өр төлбөрийн зах зээлийн ажиглагдахуйц мэдээлэл дээр суурилаагүй өгөгдлүүд

Хэрэв хөрөнгө эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход бодит үнэ цэнийн ялгаатай түвшин дамжсан мэдээллийдийг ашигласан бол Групп нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход гол илөөлсөн өгөгдлийн бодит үнэ цэнийн шаталалын хамгийн доод түвшинээр тодорхойлох ба бодит цэнийн үнэлгээний шаталалын хооронд шилжилт гарсан тохиолдолд тайлант үеийн эцэст эдгээр шилжилтүүдийг хүлээн зөвшөөрдөг.

Групп нь дараах санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмждэг.

- Үүсмэл санхүүгийн хэрэглүүр (Тодруулга 27)
- Санхүүгийн хөрөнгө оруулалт (Тодруулга 15)

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээрээ илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнийн түвшинээр нь ангилан харуулав:

	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
2024 оны 12 сарын 31-нээр				
Санхүүгийн хөрөнгө				
БҮЦБДО-оор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	21,910,646	–	–	21,910,646
Санхүүгийн өр төлбөр				
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	–	601,379	–	601,379
2023 оны 12 сарын 31-нээр				
Санхүүгийн хөрөнгө				
БҮЦБДО-оор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	2,742,303	3,818,532	1,026,430	7,587,265
Санхүүгийн өр төлбөр				
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	–	282,556	–	282,556

ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниуд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31

37. Бодит үнэ цэнийн тодруулга (үргэлжлэл)

2 болон 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрүүднийн бодит үнэ цэнийг тооцсон аргачлал болон түүнд ашигласан мэдээлэл:

Санхүүгийн хэрэглүүр	2024.12.31 ний өдрийн бодит үнэ цэн	2023.12.31 ний өдрийн бодит үнэ цэн	Бодит үнэ цэнийн шатлал	Үнэлгээний арга	Тооцоололд ашиглагдсан үндэслэл	Материаллаг нөлөө үзүүлэх боломжтой ажиглагдах боломжгүй үзүүлэлт
	мян.төг	мян.төг				
Гадаад валютын своп хэлцлүүд	(107,507)	(282,556)	Түвшин 2	Зах зээлийн үнэ	SOFR ханш, бодлогын хүү, валютын албан ханш	Ам.долларын хүүгийн өсөлт, төгрөгийн хүүгийн бууралт нь бодит үнэ цэнийг өсгөж/бууруулах ба эсрэгээр
Гадаад валютын форвард хэлцлүүд	(493,872)	–	Түвшин 2	Зах зээлийн үнэ, Хүүгийн түвшний тэнцвэр	Рено хүү болон валютын албан ханш	Йенний хүүгийн өсөлт, төгрөгийн хүүгийн бууралт нь бодит үнэ цэнийг өсгөж/бууруулах ба эсрэгээр
Өрийн хэрэглүүр	–	3,818,532	Түвшин 2	Зах зээлийн үнэ, Төсөөлсон мөнгөн гүйлгээ	Moody's-ийн шилжилт хөдөлгөөний түвшин, гадаад эх сурвалжаас авсан түүхэн мэдээлэл, ирээдүйн мөнгөн гүйлгээ	Төлөх хугацаа болон зах зээлийн хүүгийн өсөлт нь бодит үнайг бууруулж, эсрэгээр
Өмчийн хэрэглүүр	–	1,026,430	Түвшин 3	Цэвэр хөрөнгийн үнэ	Хувьцааны зах зээлийн үнэ, гүйлгээний үнэ	Цэвэр хөрөнгийн үнэ өсөх нь бодит үнайг өсгөнө

2024 болон 2023 онуудын 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилүүдийн бодит үнэ цэнийн үнэлгээний аргачлалд өөрчлөлт ороогүй болно.

3-р түвшний санхүүгийн хэрэглүүрд орсон хөдөлгөөнийг доорх хүснэгтүүдэд харуулав:

	2024 мян.төг	2023 мян.төг
Хөрөнгийн биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүрүүд		
1-р сарын 1-нээр	1,026,430	–
Нэмэгдсэн	–	1,000,756
Борлуулсан	(1,183,933)	–
Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс олсон цэвэр ашиг	157,503	25,674
12-р сарын 31-нээр	–	1,026,430

Түвшин хоорондох хөдөлгөөн (Түвшин 1, 2, 3)

Бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлалын 1, 2, 3-р түвшний хооронд шилжүүлэг хийгдээгүй.

37. Бодит үнэ цэнийн тодруулга (үргэлжлэл)

Үндсэн таамаглалын өөрчлөлтийн бодит үнэ цэнээр хэмжигдээн 3-р түвшний хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнд үзүүлэх нөлөө

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдээ үй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга зүй, таамаглалыг доор тайлбарлав.

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэй ойролцоо хөрөнгө

Хөрөвх чадвар сайтай эсвэл эргэн төлөгдхөх хугацаа богинотой (нэг жилээс богино хугацаатай) аливаа санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд дансны үнийг бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байна гэж үздэг.

Зээл, урьдчилгаа, итгэлцэл нь хувьсах хүйтэй санхүүгийн хэрэглүүрийн хувьд дансны үнэ нь бодит үнэтэй ойролцоо байна.

Дээрх таамаглал нь зээл ба урьдчилгаа, бонд, итгэлцэл хамаарна.

Тогтмол хүйтэй санхүүгийн хэрэглүүрийн хувьд бодит үнэ цэнийг хүүгийн зах зээлийн үнээр хорогдуулах замаар тодорхойлно.

38. Хөрөнгө, өр төлбөрийн хугацааны шинжилгээ

2024 оны 12 сарын 31-нээр	12 сар хүртэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт дүн мян.төг
Хөрөнгө			
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн ба банк дахь мөнгө	135,263,686	—	135,263,686
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	207,287,984	525,689,486	732,977,470
БҮЦБДО-оор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	4,718,820	17,191,826	21,910,646
Бусад санхүүгийн хөрөнгө	3,039,246	87,572	3,126,818
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад санхүүгийн бус хөрөнгө	3,140,327	—	3,140,327
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	3,309,939	—	3,309,939
Өмчлөх бусад хөрөнгө	—	2,366,355	2,366,355
Үндсэн хөрөнгө	—	13,540,144	13,540,144
Биет бус хөрөнгө	—	5,891,772	5,891,772
Ашиглах эрхтэй хөрөнгө	—	3,223,384	3,223,384
Хойшлогдсон татварын хөрөнгө	—	1,208,394	1,208,394
Гүүдвил	—	292,627	292,627
Нийт хөрөнгө	356,760,002	569,491,560	926,251,562
Өр төлбөр			
Санхүүгийн өр төлбөр			
Зээлээр авсан санхүүжилт	160,590,396	162,911,886	323,502,282
Бондын өглөг	92,830,108	31,751,811	124,581,919
Итгэлцэл	206,751,895	637,796	207,389,691
Хоёрдогч өглөг	616,629	716,527	1,333,156
Бусад санхүүгийн өр төлбөр	8,698,458	—	8,698,458
Түрээсийн өр төлбөр	908,598	2,431,963	3,340,561
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	—	601,379	601,379
Санхүүгийн бус өр төлбөр			
Бусад санхүүгийн бус өр төлбөр	919,504	—	919,504
Тайлант жилийн татварын өр төлбөр	7,361,200	—	7,361,200
Нийт өр төлбөр	478,676,788	199,051,362	677,728,150
Цэвэр дүн	(121,916,786)	370,440,198	248,523,412

ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниуд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31

38. Хөрөнгө, өр төлбөрийн хугацааны шинжилгээ (үргэлжлэл)

2023 оны 12 сарын 31-нээр	12 сар хүртэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт дүн мян.төг
Хөрөнгө			
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн ба банк дахь мөнгө	81,902,828	–	81,902,828
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	97,618,984	387,269,974	484,888,958
БҮЦБДО-оор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	3,801,076	3,786,189	7,587,265
Бусад санхүүгийн хөрөнгө	3,300,811	684,245	3,985,056
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад санхүүгийн бус хөрөнгө	2,306,321	–	2,306,321
Өмчлөх бусад хөрөнгө	–	1,025,379	1,025,379
Үндсэн хөрөнгө	–	11,674,362	11,674,362
Биет бус хөрөнгө	–	4,785,379	4,785,379
Ашиглах эрхтэй хөрөнгө	–	2,148,444	2,148,444
Гүүдвил	–	292,627	292,627
Нийт хөрөнгө	188,930,020	411,666,599	600,596,619
Санхүүгийн өр төлбөр			
Зээлээр авсан санхүүжилт	66,283,056	148,504,418	214,787,474
Бондын өглөг	65,255,376	2,188,009	67,443,385
Итгэлцэл	130,458,805	10,639,781	141,098,586
Хоёрдогч өглөг	504,403	1,314,526	1,818,929
Бусад санхүүгийн өр төлбөр	7,551,574	–	7,551,574
Түрээсийн өр төлбөр	412,150	1,735,346	2,147,496
Бусад санхүүгийн өр төлбөр	–	282,556	282,556
Санхүүгийн бус өр төлбөр			
Бусад санхүүгийн бус өр төлбөр	2,098,326	–	2,098,326
Тайлант жилийн татварын өр төлбөр	7,396,351	–	7,396,351
Хойшлогдсон татварын өр төлбөр	–	262,409	262,409
Нийт өр төлбөр	279,960,041	164,927,045	444,887,086
Цэвэр дүн	(91,030,021)	246,739,554	155,709,533

39. Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Төлөөлон удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 25/08 тоот шийдвэрийн дагуу тус группийн энгийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны жилийн эцсийн хуримтлагдсан ашгаас 4,544,657 мянган төгрөгийн ногдол ашиг зарлахаар шийдвэрлэсэн.

Төлөөлон удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 25/09 тоот шийдвэрээр тус группийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд 2024 онд олсон цэвэр ашигт суурилан 1,800,000 мянган төгрөгийн ногдол ашиг зарлахаар шийдвэрлэсэн.

2025 оны 2 дугаар сард Финтек Ази Лимитед урвуу худалдан авалтаа амжилттай гүйцэтгэсний дараа тус группийн эцсийн толгой компани Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй болсон ба дараа нь "Ай Си Эф Жэй Лимитед" нэртэйгээр группийн эцсийн толгой компани болсон.

Удирдлага нь санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.

40. Орчуулга

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агууллын зөрүү гарах тохиолдолд Англи хувилбарыг мөрдөнө.

41. Харьцуулсан мэдээлэл

Өмнөх оны зарим дүнг энэ жилийн толилуулгатай ийнцүүлэх зорилгоор дахин ангилсан болно. Эдгээр дахин ангилал нь үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтэд нөлөөлөөгүй.

	2023	2023	
	Аудитлагдсан мян.төг	Дахин ангилсан мян.төг	Аудитлагдсан - дахин ангилсан мян.төг
Санхүү байдлын тайлангийн хураангуй хэсэг			
Зээлээр авсан санхүүжилт	202,778,982	12,008,492	214,787,474
Бусад өр төлбөр	21,658,392	(12,008,492)	9,649,900
Хойшлогдсон татварын хөрөнгө	29,165	(29,165)	–
Хойшлогдсон татварын өр төлбөр	(291,574)	29,165	(262,409)
Харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа	484,418,215	470,743	484,888,958
Бусад хөрөнгө	6,762,120	(470,743)	6,291,377
Ашиг, алдагдлын тайлангийн хураангуй хэсэг			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(1,333,452)	107,595	(1,225,857)
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	(1,148,251)	(113,590)	(1,261,841)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	(507,706)	5,995	(501,711)
Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(7,423,069)	(970,603)	(8,393,672)
Үйл ажиллагааны бусад орлого	348,295	960,959	1,309,254
Үйл ажиллагааны бусад зардал	(10,385,263)	22,702	(10,362,561)
Орлогын албан татварын зардал	(15,150,719)	(13,058)	(15,163,777)
YAXT ашиглан тооцсон хүүгийн орлого	126,148,950	(412,943)	125,736,007
Хураамж, шимтгэлийн орлого	15,599,853	412,943	16,012,796
Монгол гүйлгээний тайлангийн хураангуй хэсэг			
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(147,143,220)	918,292	(146,224,928)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн цэвэр мөнгөн гүйлгээ	(6,442,638)	(762,569)	(7,205,207)
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн цэвэр мөнгөн гүйлгээ	185,591,241	(223,786)	185,367,455